



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 12 сарын 27 өдөр

Дугаар 669

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа сунгах,  
үнийг шинэчлэн тогтоох зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 7.1 дэх заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1.Булган аймаг дахь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч ашиглаж болох 15 нэрийн, нийт 30,464,440.00 (гучин сая дөрвөн зуун жаран дөрвөн мянга дөрвөн зуун дөчин ) төгрөгийн балансын үнэ бүхий хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, нийт үнийг 9,550,100.00 (есөн сая таван зуун тавин мянга нэг зуун) төгрөгөөр хавсралтад заасны дагуу шинэчлэн тогтоохыг зөвшөөрсүгэй.

2.Боловсрол, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Цэдэвсүрэн, Булган аймаг дахь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн захирлыг үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Баттулга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасны дагуу хөрөнгийн ашиглалтын хугацаа, үнийг шинэчлэн тогтоох ажлыг хоёрлох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2023 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2022 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн  
66/2 дугаар тогтоолын хавсралт

БУЛГАН АЙМАГ ДАХЬ МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ.  
ҮЛДЭГДЭЛ ӨРТӨГҮЙ, АШИГЛАХ ХУГАЦААГ СУНГАХ, ҮНИЙ ШИНЭЧЛЭН ТОГТООХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

№	Хөрөнгийн нэр марк	Тоо хэмжээ (ширхэг)	Ашиглалтад орсон огноо	Нэг бүрийн үнэ	Нийт балансын үнэ үнэ	Хур элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг	Шинэчлэн тогтоосон нэг бүрийн үнэ	Шинэчлэн тогтоосон нийт үнэ	Цаашид ашиглах хугацаа (жил)
1.1	Бонго автомашин, 23-77БУЛ	1	2013.01.20	16,400,000.00	16,400,000.00	16,400,000.00	-	5,000,000.00	5,000,000.00	2
2.1	Вакум хаалга	17.3	2012.04.30	95,000.00	1,643,500.00	1,643,500.00	-	25,000.00	432,500.00	2
3.1	Вакум хаалт	7.38	2012.04.30	85,000.00	627,300.00	627,300.00	-	20,000.00	147,600.00	2
4.1	Зиг заг машин	1	2013.10.28	866,000.00	866,000.00	866,000.00	-	300,000.00	300,000.00	2
5.1	Эсүүрийн машин	1	2013.10.28	173,990.00	173,990.00	173,990.00	-	70,000.00	70,000.00	2
6.1	Онооны самбар цах	1	2017.08.31	792,000.00	792,000.00	792,000.00	-	300,000.00	300,000.00	2
7.1	ESON 1390 а-3 принтер	1	2018.01.16	1,269,000.00	1,269,000.00	1,269,000.00	-	400,000.00	400,000.00	2
8.1	Гадна камер	4	2020.12.15	313,500.00	1,254,000.00	1,254,000.00	-	100,000.00	400,000.00	2
9.1	Дотор камер	13	2020.12.15	203,500.00	2,645,500.00	2,645,500.00	-	50,000.00	650,000.00	2
10	Хард диск	1	2020.12.15	319,550.00	319,550.00	319,550.00	-	100,000.00	100,000.00	2
11	Сапоп EOS 15000 зураг	1	2020.12.18	1,373,600.00	1,373,600.00	1,373,600.00	-	500,000.00	500,000.00	2
12	Хайлаас	50	2012.05.31	1,500.00	75,000.00	75,000.00	-	1,000.00	50,000.00	2
13	Шилэн хорго 2:50*4:30	2	2012.09.15	1,225,000.00	2,450,000.00	2,450,000.00	-	500,000.00	1,000,000.00	2
14	Толгойн угаалтуур	1	2017.09.08	275,000.00	275,000.00	275,000.00	-	100,000.00	100,000.00	2
15	Үс сандал	2	2017.10.19	150,000.00	300,000.00	300,000.00	-	50,000.00	100,000.00	2
<b>Нийт дүн</b>						<b>30,464,440.00</b>	<b>30,464,440.00</b>	<b>7,516,000.00</b>	<b>9,550,100.00</b>	<b>-</b>
						(гучин сая дөрвөн зуун жаран дөрвөн мянга дөрвөн зуун дөчин)		(долоон сая таван зуун арван зургаан мянган)	(есөн сая таван зуун тавин мянга нэг зуун)	<b>-</b>